



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/478

Ховд


Багц болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 46 дугаар зүйлийн 46.2, 46.3 дахь заалт, 2022 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний XVII.3.29 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжих Ховд аймагт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас эрх шилжин ирсэн "Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Ховд/" 7,000,000,000 төгрөг (долоон тэрбум)-ийн өртөг бүхий тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зарлахдаа зориулалт, нэр төрлийг харгалзан багц болгон хавсралтаар баталсугай.


2. 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлагдсан төсөвт өртөгт нь багтаан тоног төхөөрөмж нийлүүлэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батсүх) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хариуцан ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2414



Аймгийн Засаг даргын 2022 оны  
07 дугаар сарын 25-ны өдрийн  
А/478 дугаар захирамжийн дагсралт

**“Орон нутгийн хөгжлийг дэмжих  
"Шинэ хөдөө" төсөл /Ховд/-ийн багц**

- Хөдөө аж ахуй, газар тариалангийн тоног төхөөрөмж 1 дүгээр багц -5,156,000,000
- Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн тоног төхөөрөмж 2 дугаар багц - 1,219,000,000
- Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмж  
3 дугаар багц - 392,500,000
- Хүлэмжийн аж ахуйн тоног төхөөрөмж 4 дүгээр багц - 232,500,000